



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№65 /509/

2023.04.20

Цаг үе, үйл явдал

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 123 ДУГААР АНГИД АЖИЛЛАЛАА



УХНАА
АРДЫН
ЦЭРЭГ
ЗЭВСЭГТ
ХҮЧНИЙ
123
ДУГААР
АНГИД
АЖИЛЛАЛАА



Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх Ховд аймагт ажиллах үеэрээ Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн алба хаагчидтай уулзлаа. Түүнийг дагалдаж ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба, Хуурай замын цэргийн командлагч бригадын генерал Ч.Цогтжаргал тэргүүтэй салбарын удирдлагууд ажилласан юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийг хүрэлцэн ирэхэд ангийн бие бүрэлдэхүүн жагсаж, хүндэт харуул ёслол төгөлдөр угтлаа. Үүний дараа тус ангийн захирагч хурандаа Х.Энхболд ангийн түүх, дайчин уламжлал, өнөөгийн байдал, хийгдсэн бүтээлч ажлууд, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааг танилцуулсны зэрэгцээ ёс зүйтэй байж, цэргийн алба хаагчдын сахилга хариуцлагыг бэхжүүлэх, тэдний бүтээлч санаачлагыг дэмжих талаар анхааран ажиллаж байгаагаа уламжлав. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх

Ардын Хатанбаатар С.Магсаржавын нэрэмжит Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 123 дугаар ангид ажиллах хугацаандаа хугацаат цэргийн алба хаагчдын сурч боловсрох орчин нөхцөлтэй танилцсан бөгөөд ангийн "Алдарын тасалгаа"-гаар зочилж хүндэт дэвтэрт сэтгэгдлээ үлдээсэн юм. Мөн ангийн зарим объект, барилга байгууламж, "Соёл спортын төв"-ийн үйл ажиллагаа болон ашиглагдаж байгаа Зэвсэглэл, техникийн бэлэн байдалтай танилцсан юм. Үргэлжлүүлэн тус ангийн нийт бие бүрэлдэхүүнтэй уулзаж "Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй "Тэрбум мод", "Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөн, "Хүнсний хувьсгал" хөтөлбөрийн талаар танилцуулав. Тэрбээр хэлсэн үгэндээ, улс орны тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах, ард түмнийг соён гэгээрүүлэх үйлсэд Төрийн цэргийн байгууллагын офицер, ахлагч, ажилтан албан хаагчдын үүрэг ихээхэн чухал гэдгийг онцлоод Засгийн газрын шинэчлэлийн бодлого "Алсын

хараа 2050" урт хугацааны хөгжлийн бодлого болон Зэвсэгт хүчний өөрчлөлт шинэчлэлийн талаар өөрийн байр суурийг илэрхийлж, санал бодлоо хуваалцлаа.

Мөн шинэ зууны хөгжил дэвшлийн түүчээ болсон эрхэм та бүхэн цэргийн шинэчлэлийн бодлогыг тууштай хэрэгжүүлж, цаг ямагт манлайлан ажиллана гэдэгт итгэлтэй байна хэмээн тодотгоод "Эх орноо батлан хамгаалах нэр төртэй, нэн хариуцлагатай үйл хэрэгт нь өндөр амжилт хүсье. Цэргийн алба хаагч та бүхний бат найдвартай ар тал болсон гэр бүл, хань ижил, үр хүүхдүүдэд чин сэтгэлийн талархал илэрхийлж, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе" гэв.

Уулзалтын төгсгөлд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагч хурандаа Х.Энхболдод Их эзэн Чингис хааны эш хөргийг гардуулсан юм.

Дэслэгч
Б.ЭРДЭНЭБАТ

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ЦЭРЭГ-СПОРТЫН "ДӨЛ" ТЭМЦЭЭНИЙ НЭЭЛТ БОЛЛОО



Хүүхэд, залуучуудад цэрэг-эх оронч хүмүүжил олгох, эх орноороо бахархах үзлийг төлөвшүүлэх, тэдэнд бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэл, тэвчээр хатуужил

олгох, ирээдүйн мэргэжлээ зөв сонгоход дэмжлэг үзүүлж, Зэвсэгт хүчний залгамж халааг бэлтгэх зорилготой цэрэг-спортын "Дөл-2023" цогцолбор тэмцээн улс орон

даяар өрнөж байна.

Тухайлбал, Өнөөдөр Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн байрлалд Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб, Боловсролын хэлтэс хамтран дүүргийн Засаг даргын нэрэмжит цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээний нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа.

Нээлтийн ажиллагаанд Нийслэл, Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын удирдлагууд, Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн захирагч болон тус дүүргийн ЕБС-иудын багш, сурагчид оролцлоо.

Хүрэлцэн ирсэн зочид, төлөөлөгчид, тэмцээнд оролцож буй хүүхэд залууст зориулан ЦДБЭЧ-ын уран бүтээлч А.Дөлбадрах "Цэрэг эрс" дуугаа өргөн барьсны

зэрэгцээ Зэвсэгт хүчний 013, 150 дугаар ангийн офицер, ахлагч, хугацаат цэргийн алба хаагчид жагсаалын болон гардан тулааны үзүүлэх тоглолтоо толилууллаа.

Хан-Уул дүүргийн аварга шалгаруулах энэ удаагийн "Дөл" тэмцээнд Ерөнхий боловсролын 16 сургуулийн, 200 гаруй сурагчид хурд хүч, авхаалж самбаа, мэдлэг чадвараа сорин өрсөлдөнө.

Ташрамд дуулгахад Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн ивээл дор 2022 онд зохион байгуулагдсан Улсын аварга шалгаруулах "Дөл" тэмцээнд тус дүүргийн 7 дугаар сургуулийн баг тамирчид амжилттай оролцож тэргүүн байрыг эзэлж байсан юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 3	☁️ -7


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 41	☁️ 28

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,485	3,492
EUR 🇪🇺	3,835	3,855
CNY 🇨🇳	507	509.80
RUB 🇷🇺	42,30	42.80
JPY 🇯🇵	25.90	26.20
KRW 🇰🇷	2.64	2.67

ЗУРХАЙ



2023.04.20 /ПҮРЭВ ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 29

**ХАВРЫН ДҮНД ХӨХӨГЧИН
ТУУЛАЙ САР
ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ШАР
БИЧ ӨДӨР**

Үс засуулбал:

**Эрлэг лугаа учирна
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.54-19.48
Барилдлага:
Рашаан
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
Өтлөх үхэхүй**

Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Эл өдөр санасан хэрэг түргэн бүтнэ. Бүтээл үйлдэх, тус чухалчлах, хэл ам дарах, башир, хатуу, түргэн үйлнээ сайн, эд хураах, номын өглөг өгөх, угаах, гадагш эд өгөхөд сайн. Зүүн нүд татвал хувцас олдох, баруун нь бол элчтэй учрах, хөл тагнай татвал өөрийн гэрт үзэсгэлэн болох, бие татвал бурханыг дурьдахуй болой.

КОРОНАВИРУС ДЭЛХИ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 686,008,234

Эдгэрсэн

Нийт: 658,659,234

Нас барсан

Нийт: 6,844,808

Цахим шууданд

“МИНИЙ ХААЖ БУЙ ЦЭРГИЙН АЛБА”-ЫН ТЭРГҮҮН БАЙРЫН ЭСЭЭ



Монгол цэргийн нэгдсэн холбоо, “Отгон тэнгэр” их сургууль хамтран Зэвсэгт хүчин, Хил хамгаалах, Дотоодын цэрэгт хугацаат цэргийн алба хааж байгаа түрүүч, байлдагч нарын дунд “Миний хааж буй цэргийн алба” сэдэвт эсээ бичлэгийн уралдааныг зарласан билээ.

Уралдааны тэргүүн байрт Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн дэд түрүүч М.Алтанбагана, дэд байрт Хилийн цэргийн 0214 дүгээр ангийн байлдагч Д.Ууганбаяр, гутгаар байрт Хилийн цэргийн 0198 дугаар ангийн байлдагч Ч.Чингүүн шалгарч, шилдэг 10-т Зэвсэгт хүчний 017, 120, 327, 336 дугаар ангийн байлдагч Б.Төгөлдөр, Б.Билгүүнбаяр, А.Билгүүн, Д.Билгүүдэй, Хилийн цэргийн 0198 дугаар ангийн байлдагч Ү.Дорждэрэм, Б.Төмөрсүх нар багтаж, шагнагдсан юм.

Тэгвэл эх орон, тусгаар тогтнол, эр цэргийн албаны тухай өгүүлсэн олон зуун эсээ бичлэгээс шалгарсан Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч, дэд түрүүч Мөнхтөрийн Алтанбаганын “Цэргийн алба-Эрдмийн алба, Цэргийн алба-Амьдралын сургууль” нийтлэлийг хамтдаа задалж уншъя. Танд таалагдана гэдэгт итгэлтэй байна. Үүнээс өмнө эрхэм дэд түрүүчийг товчлон танилцуулахад 2000 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Дорнод аймгийн Хэрлэн суманд төрсөн, эхээс зургаалаа. Аав Х.Мөнхтөр, ээж Г.Баярцэцэг, гурван дүүгийн хамт амьдардаг. Ерөнхий боловсролын сургуулиа алтан медальтай төгсөж, 2018-2022 онд ХААИС-д механик инженер мэргэжлээр суралцан төгсөж, цэргийн албанд татагдан иртлээ “Таван богд” ХХК-д мэргэжлээрээ ажиллаж байсан залуу юм.

Хуучин цагт бүр тодруулбал миний авыг бага балчир явсан цаг үед эрэгтэй хүүхэд төрвөл “Эх орноо хамгаалах эр цэрэг төрлөө” гэж гэр бүлээрээ, ахан дүүсээрээ, нутаг олноороо баярлаж хөөрдөг байв. Миний аав ч гэсэн тийм л бахархал дунд төрж аав, ээж нь “Эх орноо хамгаалах хүү юм шүү дээ” гэж өхөөрдөж өсгөсөн гэдэг. Харин өнөөдөр энэ өхөөрдөл, эх орон гэсэн ухагдахуунаар хүүгээ хайрлаж өсгөдөг тогтолцоо байдаг болов уу. Би лав ойр тойрны хүрээндээ сонсоогүй юм байна. “Эх орноо хүү” гэж хэл, хөлд нь орохоос нь эхлэн “сануулж” өсгөх нь өөрөө тухайн хүүхдийн сэтгэхүйд асар том ухаарал, сургамж, үүрэг хариуцлагыг тээхэд тусалдаг гэж би боддог. Тийм хүмүүжлээр өссөн хүүхэд зурагтаар, социалаар мянга үзээд ч өөртөө наадаггүй цэрэг-эх оронч үзэл хүмүүжлийн зүгээр л тээгч болсон байдаг юм. Эр хүн гэж хэн бэ. Эр хүн ямар байх ёстой вэ. Энэ олон асуултыг залуучууд яг өөрөөсөө асуугаасай гэж заримдаа боддог. Эр хүн гэр бүлээ, цаашлаад улс орноо авч явах ёстой. Үүний тулд сурч

боловсорч, ажиллаж хөдөлмөрлөх ёстой. Магад боловсрол эзэмшихгүй ч байж болно.

Боловсролоос илүү хүмүүжил, төлөвшил, харилцаа хандлага амьдрал дээр хамгийн чухал байдаг нь бичигдээгүй хууль. “Таны бичсэнчлэн би суралцаж, хөдөлмөрлөж байна, тэгээд юу гэж” надаас хэн нэгэн асуух байх. Тэгвэл “Та эх орныхоо өмнө хүлээсэн үүргээ биелүүл” гэж хэлнэ. Эр хүн болж л төрсөн юм бол эр цэргийн албанд морд, монгол хэмээх бахархал, омогшлыг мэдэрч, дайсан халдахын цагт ямар үүрэгтэй эр хүн бэ гэдгээ ойлго гэж нэмж хэлнэ. Эр хүн болж төрсний давуу чанар, бахархал нь өөрөө эр цэргийн алба хаагч болж гялалзахдаа юм шүү дээ.

“Магад та цэрэгт ирээд юу ойлгов” гэж асуух л байх бас. Энэ их энгийн. Хугацаат цэргийн алба хаагч бүрийн хэлдэг “жижүүр”-ийн үг буюу захирах, захирагдах, тэсвэр хатуужил, үг даах чадвартай боллоо гэж хэлмээр байна. Гэхдээ хамгийн чухал нь юу вэ гээч. Төлөвлөлт зохион байгуулалттай болж, бусадтай харилцах асар том соёлоос суралцаж. Ялангуяа, харилцаанаас харилцаа үүснэ гэдэг шиг өөрөөс хэд дүү ч байсан “Та” гэдэг харилцаа эерэг уур амьсгалыг харилцагчдын дунд бүрдүүлдэг юм байна. Амьдрал дээр энэ нь хэвшил болж үлддэг онцгой чанар. Төлөвлөлт зохион байгуулалт, эмх цэгц, дэг журам нь мөн л халагдсаны дараа амьдралд хэрэг болдог өгөгдөл. Бүр миний багийн найз юм юу руу үзэрсэн, хэлсэн ярьснаасаа хэд буцаж, тайван бус харилцаатай, сэтгэл зүй нь тогтворгүй мэт залуу байсан бол цэргийн албанд явж ирээд тууштай, эмх цэгцийг эрхэмлэдэг болсон нь миний энэ албанд дурлах шалтгаан байсныг онцлохыг хүсэж байна. Миний найз ингэж өөрчлөгдөж байхад би яагаад чадахгүй гэж. Эрт дээр үед хөвгүүдээ эр цэргийн албаар дамжуулж хүмүүжүүлж, эх оронч иргэн бэлтгэдэг тогтолцоо энэ цаг үеийн эцэг эхийн сэтгэлд хэвээр байгаа юм байна гэдгийг аавынхаа “Цэрэгт яв миний хүү” гэдэг үгнээс мэдэрсэн. Би тийм дэггүй нөхөр бас биш л дээ. Зүгээр л цэргийн алба гэдэг эрдмийн алба, амьдралын сургууль гэдгийг аль эртнээсээ хүлээн зөвшөөрч, энэ шат дамжлагыг дамжсан эр хүн зөв амьдарна гэдэг ухагдахуун миний аавд болон надад байдаг болоод л тэр.

Цэрэгт ирэхээс өмнө “Аяллын цаг” нэвтрүүлгийн хөтөлгөч Г.Бадамсамбуу ахын нэг ярилцлагыг уншсан нь бас их юм бодогдуулсан. Өнөөдөр нийгэм цаг үе хэтэрхий цахимжсан, соёлжсон цагаан гартны эрин ирлээ гэж. Та бод л доо. Хөл, хэлд орж байгаа хүүхэд бүр эцэг эхийнхээ утсыг булаацалдаж тоглоно гээд уйлдаг биздээ. Энэ хүүхдүүд том болохоороо хөтөлгөч ахын

хэлсэнчлэн цахимжсан залуус л гарч ирнэ. Техник технологийн хөгжилдөө л гаргуун. “Энэ цаг үед ийм л залуус хэрэгтэй биздээ” гэж өөр нэгэн бас уншиж байхдаа асуух байх. Бас л хэлье. Хамгийн хүчтэй зэвсэг юу гээч. Буу зэвсэг, орчин үеийн техникээс илүү бүрэн бэлтгэгдсэн эр цэрэг л байхгүй юу. Тэгэхээр үүнийг цөөн хэсэг нь ойлгоод л цэрэгт ирээд, үлдсэн хэсэг нь цахимжсан байдлаараа яваад байвал тэнцвэргүй байдал үүснэ.

Өөрөөр хэлбэл, цахимжсан, соёлжсон энэ эрин үеийн залуусыг цэргийн албаар дамжуулж сургаж бэлтгэх, эх оронч үзэл, хүмүүжлийг нь өвлүүлэх ёстой. БНМАУ-ын баатар, төр нийгмийн нэрт зүтгэлтэн Х.Чойбалсан “Эрхэмлэж яваарай хэмээн машид итгэн эрх чөлөө, тусгаар тогтнолыг та нарт үлдээв” гэж хэлсэн байдаг. Залуус бид эх орноо хамгаалах чухал үүргийг өвөг дээдсээсээ хүлээн авсан. Тийм учраас бид үүргээ ухамсарлаж цэргийн албанд татагдан эх орноо хамгаалах чадварыг эзэмших хэрэгтэй. Хэзээд бэлэн байх нь эр хүн таны үүрэг юм шүү.

“Цэргийн орчин нь ямар вэ. Дарга нь загнаж зандралд байдаг уу” гэж асуувал ингэж би хариулна. Ийм бодол тээж байгаа таныг би буруутгахгүй. Учир нь хэт цахимжсан энэ нийгэмд социалаар бусдыг, байгууллагыг харлуулахад их амархан шүү дээ. “Тэгжээ” гэхэд л нийгмээрээ шуурчихна. Эргээд мянган удаа залруулаад ч өмнөх авсан мэдээлэлдээ л итгээд байдаг. Үүнийг нийгэм массаараа муу мэдээнд баясамтгай болсонтой холбоотой байх гэж ойлгодог. Би ч гэсэн ялгаагүй, цэрэгт ирэхээсээ өмнө Зэвсэгт хүчний талаарх ойлголт тийм ч сайн байгаагүйгээ нуухгүй. Харин бодит байдалд Зэвсэгт хүчин нийгэм, цаг үетэйгээ нийлүүлж маш их өөрчлөгдөж байна. “Хайрцаглагдсан” үзэл бодлоосоо ч салж, өөрсдийгөө өөрчлөхөөр хичээж байна.

Хугацаат цэргийн алба гэдэг зөвхөн цэргийн эрдэмд суралцаар байгаад халагддаг биш юм байна. Хэрэв тухайн байлдагч өөрөө хүсвэл элсэлтийн ерөнхий шалгалт өгөх, их дээд сургуульд конкурс өгөх, гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах, бүтээн байгуулалтад оролцох, аймгийнхаа МСҮТ-д нийгэмд хэрэгцээтэй мэргэжлээр суралцах, жолооны болон англи хэлний сургалт дамжаанд хамрагдах гээд олон өөрчлөлт, боломжуудыг нэрлэнэ. Анги байгууллага нь өөрөө санал ч тавьдаг юм билээ. “Та тэгэх үү, ингэх үү” гээд. Тэгэхээр системийн хувьд цаг үетэйгээ нийцүүлж томоохон өөрчлөлтийг бий болгож байгааг жирийн нэгэн дэд түрүүчийн хувьд олж харж, түүнийг нь бичих боломж эсээ бичлэгийн уралдаанаар гарч ирсэнд маш их баяртай байна.

Хэдий цэргийнхний харилцаа хандлагад эерэг өөрчлөлт гарч, хугацаат цэргийн албыг олон төрлөөр хөгжүүлж байгаа ч зэвсэглэл техникийн хувьд хүндрэлтэй асуудал нь хэвээр байгааг ч анзаарсан. Гэхдээ энэ бол хугацаат цэргийн алба хаах ёстой эрчүүд бидний гэхээс илүү төр засгийн шийдвэрлэх асуудал тул энэ сэдвийг дурдаж бичих нь хэрэггүй байх.

Эцэст нь нэг л зүйлийг онцолъя. Цэргийн албанд татагдаж ирсэн залуусын бодол мөрөөдөл илүү алсыг харж, цаашдын амьдралаа төлөвлөх, ирээдүйд ямар боломж байгааг мэдэх, цуг алба хааж байгаа он жавуудаасаа шинэ санаа авах, суралцах, амьдралын зөв чигээ олох арга замуудаа нээж чаддаг нь үнэн.

Сэтгэл зүй болоод бие бялдрын өөрчлөлтийг мэдрэх зам бол цэргийн алба. Үүний тулд олон мянган офицер, ахлагч цэргийн тангараг дор ажиллаж амьдарч, бидний хөдөлмөрийн үр шимээр өөрийгөө болон найзыгаа хэрхэн өөрчлөгдөж байгааг мэдрэх урамтай байна. Урмаар цэнэглэгдэж яваа сэтгэл хөөрөлдөө автаж энэхүү сунжирсан эсээг бичлээ. Цэргийн албаны сайхныг ойлгосон жирийн нэгэн аавын хүү билээ, би ...

Дэд түрүүч
М.АЛТАНБАГАНА

АРТИЛЛЕРЧДЫН МЭРГЭЖЛЭЭРЭЭ БАХАРСАН ӨДРҮҮД ...



Зэвсэгт хүчний артиллерчдын нэгдсэн хээрийн гаралт найман хоногийн хугацаатайгаар Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвийг түшиглэн амжилттай зохион байгуулагдлаа.

Нэгдсэн хээрийн гаралтад Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын их буучид буюу артиллерчин офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчид оролцсон бөгөөд холоос зорьж ирсэн нь Зэвсэгт хүчний 167, 186, 256, 327, 331, 336 дугаар ангийн дайчид байлаа.

Нэгдсэн гаралтын өмнө нэгтгэл, ангиудын захирагчийн нэрэмжит мэргэжлээрээ бахархах, ажилдаа гарших, гар нийлэмжтэй хамтын ажиллагааг бэхжүүлэх хүрээнд хэд хэдэн тэмцээн уралдаан явагдсан юм.

Тухайлбал, Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн захирагчийн нэрэмжит “Тооцоочин гал удирдагч” шалгаруулах тэмцээний тэргүүн байрт ахлах ахлагч Д.Пүрэвсүрэн (123), дэд байрт байлдагч С.Мөнх-Эрдэнэ (120), гутгаар байрт дэслэгч Б.Эрдэнэтөгс (167) шалгарч, тооцоотой гал удирдагч гэдгээ нотоллоо.

Зэвсэгт хүчний 284 дүгээр ангийн нэрэмжит “Артиллерийн мэргэжлийн аварга” шалгаруулах тэмцээний офицерын төрөлд тэргүүн байрт ахлах дэслэгч Ж.Дулаанжаргал (327), дэд байрт дэслэгч Э.Золжаргал (120), ахлагчийн төрөлд тэргүүн байрт ахлах ахлагч Б.Уранбаатар (120), дэд байрт ахлах ахлагч Б.Төгсбаяр (350) шалгарч, мэргэжлээрээ аваргалаа.

Зэвсэгт хүчний 120 дугаар ангийнхнаас алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, нөхөрсөг дулаан уур амьсгалыг

бэхжүүлэх хүрээнд зохион байгуулсан “Чанга шивнээ” хөгжөөнт тэмцээнд ахлах дэслэгч Д.Мөнхбаяр, ахлагч Н.Адьяа (331) нар тэргүүлж, ахлах байлдагч Н.Одбаяр, байлдагч Э.Очир (120) нар удааллаа.

Түүнчлэн Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн “Ахмадын зөвлөл”-өөс тус ангийн офицер, ахлагч, түрүүч, байлдагч нарын дунд уламжлал болгон зохион байгуулдаг тэмцээнийг зохион явуулж, шагналыг нь гардуулав. Ахмад артиллерчид “Их буучин гэдэг энэ онцгой мэргэжлээрээ бахархаж, өөрийгөө хөгжүүлэхийн төлөө тасралтгүй зүтгэж яваарай. Артиллерчдын залгамжийг нэр төртэй дааж яваа залуусаараа бид үргэлж бахархдаг билээ” хэмээн онцолж байсан юм. “Шилдэг батарей”-гаар тус ангийн “Танк эсэргүүцэх артиллерийн батарей”, “Шилдэг офицер”-оор ахлах дэслэгч Д.Доржсүрэн, “Шилдэг ахлагч”-аар сургагч ахлагч Ц.Ганболд, “Шилдэг цэргийн гэрээт алба хаагч”-аар түрүүч Л.Энхбаяр, “Тооцоочин дайчин”-аар байлдагч С.Мөнх-Эрдэнэ, “Онц буудагч”-аар байлдагч Н.Энхтүвшин, Б.Мөнх-Оргил нар шалгарч, “Онц буудагч” тэмдгээр түрүүч Т.Мягмаржав, дэд түрүүч Э.Оргилбаатар, Д.Бяцхансүх, ахлах байлдагч Б.Баттүшиг, байлдагч Г.Өсөхбаяр, “Онц сурлагатан” тэмдгээр дэд түрүүч Б.Бат-Эрдэнэ, ахлах байлдагч О.Санчир, Т.Адьяаням, байлдагч Н.Отгонхүү, С.Мөнх-Эрдэнэ, “Тамирчин дайчин” тэмдгээр дэд түрүүч Б.Мөнхшагай, О.Төгс-Эрдэнэ, байлдагч Э.Энхбат, Э.Дөлгөөн, Б.Нямцогт нар шагнагдлаа.

Ахмад
Т.МЯГМАРСҮРЭН

